



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2020.10.16 № 1а/4384
танай -ны № -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Б.БАЯРСАЙХАН ТАНАА

Г Асуултын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан таны тавьсан асуулгад дараах хариуг хүргүүлж байна.

НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-д Хүчирхийллийн бүх хэлбэр болон хүчирхийллийн шалтгаантай нас баралтын түвшинг үлэмж хэмжээгээр бууруулах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, хүний наймаа, тамлан зовоох зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох” тухай заасан байдаг.

ДЭМБ-ын баримт бичигт “Жендэрийн уламжлалт үзэл хандлага, зан үйлээс үйдэлтэй хүчирхийлэл нь хувь хүн, гэр бүл, нийгмийн хөгжил, эдийн засагт ихээхэн хор уршиг учруулж буй нь дэлхийн хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг юм. Үүнд зөвхөн эрүүл мэндийн бус бусад салбарын оролцоог хангасан богино ба урт хугацааны урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх цогц үйлчилгээг хөгжүүлэх нь улс орон бүрийн төрийн бодлогын түвшинд авч үзэх ёстой асуудал” хэмээн онцлон тэмдэглэсэн байдал билээ.

Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл нь гол төлөв эмэгтэйчүүд охидын эсрэг үйлдэгдэж байгаа ч гол хохирогчид нь хүүхдүүд болж байна. Эрүүл мэндийн салбар хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдийг хүчирхийлэлийн дарамтад өртсөнийг эрт шатанд нь илрүүлж, гэмтэл бэртэл авахаас урьдчилан сэргийлэхийн тулд аюулгүй хамгаалагдсан орчинд, бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн багийн цогц үйлчилгээг цаг алдалгүй, чанартай хүргэх зорилго тавин ажиллаж байна.

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгч болон хүүхдийг хэвийн байдалдаа эргэн ороход дэмжин туслахад нийгмийн, халамжийн, эрүүл мэндийн, сэтгэл зүйн, хууль эрх зүйн салбар дундын оролцоог зангиdsan зохион байгуулалт бүхий үр дүнтэй цогц үйлчилгээг “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр үзүүлдэг.

Таны ирүүлсэн албан бичгийн дагуу дараах тоо баримтыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:

1. 2020 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн байдлаар Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төвөөр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 810 хүн үйлчлүүлсэнээс насанд хүрсэн 717, хүүхэд 93 эмнэлгийн тусlamж үйлчилгээ болон бусад шаардлагатай үйлчилгээг цогцоор нь авсан байна.

144208892

2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын ихэнх хувь нь хамтран амьдрагч болон нөхрийн зүгээс хүчирхийлэлд өртөж байна. Гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалан гарсан осол гэмтлийн тандалтыг он тус бүрээр нарийвчлан авч үзвэл, 2017 оны байдлаар хамтран амьдрагч болон нөхөртөө хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн тоо 1461, эцэг эхдээ хүчирхийлэлд өртсөн 149, бусад хамаатан садандаа хүчирхийлэлд өртсөн 521, 2018 оны байдлаар хамтран амьдрагч болон нөхөртөө хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн тоо 1704, эцэг эхдээ хүчирхийлэлд өртсөн 150, бусад хамаатан садандаа хүчирхийлэлд өртсөн 612 байна. 2019 оны байдлаар үзэхэд хамтран амьдрагч болон нөхөртөө хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн тоо 1717, эцэг эхдээ хүчирхийлэлд өртсөн 157, бусад хамаатан садандаа хүчирхийлэлд өртсөн 700 байна. Харин 2020 оны эхний 8 сарын байдлаар хамтран амьдрагч болон нөхөртөө хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн тоо 1161, эцэг эхдээ хүчирхийлэлд өртсөн 113, бусад хамаатан садандаа хүчирхийлэлд өртсөн 463 байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч, хохирогчдын тоо жил ирэх тусам өсөж байгаа нь харагдаж байна.

3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нь сэтгэлзүй, бие маш бодиороо гэмтэл бэртэл авч хохирдог. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас ирсэн хүмүүсийн ихэнх нь тархи толгойдоо бэртэл авсан байдаг, бэртэж гэмтсэн хэлбэрийг нь авч үзвэл зөвлөн эдийн гэмтэл ихэнх хувийг эзэлдэг. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэнийг нэг цэгийн үйлчилгээний төвд хүлээн авч эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлсний дараа шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчийн оношлогоо, эмчилгээнд хамруулж, хүчирхийллийн өндөр эрсдэлтэй бол 24-72 цагийн түр хамгаалах байранд байрлуулж, эрүүл мэндийн болон нийгмийн тусlamж үйлчилгээг үзүүлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусlamж үзүүлэхэд хамгийн гол анхаарах асуудал нь хүчирхийллийг эрт илрүүлэх явдал юм. Иймд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хэвийн байдалдаа эргэн ороход дэмжин туслах, нийгмийн, халамжийн, эрүүл мэндийн, сэтгэл зүйн, нөхөн сэргээх үйлчилгээг цогцоор нь үзүүлэх салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Нэмэлт шаардлагатай мэдээллийг хүснэгт хавсралтаар хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

САЙД



Т.МӨНХСАЙХАН

**Хавсралт 1. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд үзүүлсэн тусlamж,
үйлчилгээний талаарх тоон мэдээлэл**

2017-2020 оны Нэг цэгийн үйлчилгээний төв/Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хүний тоо, үзүүлсэн үйлчилгээний төрөлөөр											
Он	Насанд хүрсэн /эр/	Насанд хүрсэн /эм/	Хүүхэд /эр/	Хүүхэд /эм/	Хамтарсан багаар шийдвэрлэсэн кейсийн тоо	Бүрэн шийдвэрлэгдсэн кейс /ял/ онцсон, гэрлэлт салгуулсан гэх мэт авсан арга хэмжээ/*	Үйлчилгээний төрөл	Үйлчлүүлэг чийн тоо /үйлчилгээнд ийн төрөлөөр/	Утсаар үйлчилгээ авсан хүний тоо	Биеэр үйлчилгээ авсан хүний тоо	Хэрхэн танай төвд хандсан бэ?/Цагдаагас, эмнэлгээс, өөрөө гэх мэт/
2017 он	15	646	150	149	320	153	Аюулгүй байдлын хамгаалалт	380	120	490	Өөрөө-520
							Эмнэлгийн тусlamж үйлчилгээ	910			Цагдаагаар-390
							Сэтгэлзүйн үйлчилгээ	150			Өөрөө-490
							Холбон зуучлах үйлчилгээ	910			Цагдаа-258
							Бусад	50			Өөрөө- 310
2018 он	8	650	60	30	290	110	Аюулгүй байдлын хамгаалалт	250	150	450	Цагдаа - 196
							Эмнэлгийн тусlamж үйлчилгээ	748			Өөрөө-310
							Сэтгэлзүйн үйлчилгээ	210			Цагдаа-258
							Холбон зуучлах үйлчилгээ	748			Өөрөө-520
							Бусад	5			Цагдаагаар-390
2019 он	6	491	75	51	250	120	Аюулгүй байдлын хамгаалалт	230	210	506	Өөрөө-310
							Эмнэлгийн тусlamж үйлчилгээ	617			Цагдаа-258
							Сэтгэлзүйн үйлчилгээ	210			Өөрөө-520
							Холбон зуучлах үйлчилгээ	506			Цагдаагаар-390

							Бусад	8			
2020. 10.08	9	708	68	25	310	180	Аюулгүй байдлын хамгаалалт	415			
							Эмнэлгийн тусlamж үйлчилгээ	810			Өөрөө -511
							Сэтгэлзүйн үйлчилгээ	200			
							Холбон зуучлах үйлчилгээ	810			Цагдаа -292
							Бусад	4			

Хавсралт 2. Гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалан гарсан осол гэмтлийн тандалт, мэдээлэл

Хүчирхийлэгч, хохирогч хоорондын холбоо	2017 он	2018 он	2019 он	2020 оны эхний 8 сар
Гэр бүлийн хүн (хамтран амьдрагч)	1461	1704	1717	1161
Эцэг эх	149	150	157	113
Бусад хамаатан	521	612	700	463
Бусад	14178	15378	15106	8106
Нийт	16309	17844	17680	9843